



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 035

Зуунмод

Шинжээч томилох тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 67 дугаар зүйлийн 67.5, "Шүүхийн шинжилгээний тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь заалт, "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар" -ын 2021 оны А/134 журам, Төв аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 151/Ш32022/02641 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 04 дүгээр хороо, 15 дугаар хороолол, 43 дугаар байрны 28 тоотод оршин суух Жанжинхүү овогт Жамбалын Лосолмаагийн нэхэмжлэлтэй Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, 13 дугаар хороолол, 396 байрны 2 тоотод оршин суух Баяууд овогт Буянжаргалын Төрмөнхөд холбогдох иргэний хэрэгт шинжээчээр манай байгууллагыг томилсон тул шинжээчээр ажиллах албан тушаалтнаар Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Цогжавхаа)-г томилсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүгчийн захирамжид дурьдсан асуултад дүгнэлт гаргаж, Төв аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлэх, гарсан зардлыг тооцож нэхэмжлэгч, хариуцагч талаас гаргуулахыг шинжээч Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Цогжавхаа) -д даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын удирдлагын хэлтсийн дарга (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАСАНЖАРГАЛ

41220124